



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/309

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Харааны бэрхшээлтэй хүүхдэд орон зай, хөдөлгөөний баримжаа олгох сургалтын жишиг хөтөлбөр”-ийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Батлагдсан сургалтын хөтөлбөрийг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Г.Ням-Очир/, Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/-т, харааны бэрхшээлтэй хүүхэд суралцаж буй сургалтын байгууллагын удирдлага, багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг чанартай зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142111117



ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД АХУЙН БАРИМЖАА ОЛГОХ СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

Нийтлэг үндэслэл:

Харааны бэрхшээлтэй хүүхэд гэрийн болон сургуулийн орчинд бие даан амьдрах, суралцахад нь нэн шаардлагатай чадвар эзэмшүүлэх зорилго бүхий “Ахуйн баримжаа” ганцаарчилсан сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Энэхүү хичээлийн жишиг хөтөлбөрийг боловсруулан батлах нь багш нарт харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх чиг баримжаа болох юм.

Ахуйн баримжаа хичээл нь харааны бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн онцлогт нь тохируулан өөртөө үйлчлэх, бусдад туслах, бусадтай харилцах, хамтран ажиллаж, суралцах явцдаа нийгэмших, аюулгүй байдлаа ханган ажиллаж сурах, хувийн ариун цэврээ сахих, эмх цэгцтэй байх чадварт сурах, тэдний бие даан хөгжих зэрэг бүхий л сурах боломжийг ялгаварлалгүйгээр олгох, харааны бэрхшээлтэй хүүхдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тэдний эрхийг хүндэтгэсэн нийгмийн орчныг буй болгох, оролцоог нэмэгдүүлэх, тэгш хамруулах боловсролын үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх явдал юм.

Энэхүү хөтөлбөрийг харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй бүх багш, сурган хүмүүжүүлэгчид ашиглаж болно.

Жишиг хөтөлбөрийн боловсруулахад баримталсан зарчим:

- Хүүхдийн эрт үеийн хөгжлийн үнэлгээ, онцлог хэрэгцээ, чадварт суурилсан байх
- Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, ялгаварлан гадуурхалтгүй, тэгш, хүртээмжтэй байх;
- Хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн агуулгыг уян хатан сонгох боломжтой байх;
- Багш хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөх, зохион байгуулах, ахиц өөрчлөлтийг үнэлэх боломжтой байх.

Хөтөлбөрийн зорилго:

“Ахуйн баримжаа” сургалтын жишиг хөтөлбөрийн зорилго нь харааны бэрхшээлтэй хүүхдэд тэмтрэх мэдрэхүйн тусламжтайгаар өөртөө үйлчлэх энгийн чадварыг хөгжүүлэх, танил бус эд юмсыг танин мэдэх арга барил, бие даан аюулгүй амьдрахад бэлтгэх чадвар эзэмшүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн агуулга:

- *Бие даан хооллож сурах:*
 - Аяга, таваг, данх зэрэг савтай цай, хоолны температурыг мэдрэх, халуун хоол, цайг асгахаас болгоомжлох;
 - Ширээнд суух, устай аягыг хайж олох, аягатай шингэнийг зөв барьж уух;
 - Аяга, тавагтай хоолыг мэдэрч, халбага, сэрээг зөв хэрэглэх;
 - Хоол идэхдээ ширээ, аяга, халбаганыхаа зайг тохируулах;

- Хоолны ширээ, сандал, гал тогооны хэрэгслийг мэдэрч, ялган таних;
 - Хоолны ширээ, сандлын өндрийг мэдэрч, зөв суух;
 - Аяга, таваг, халбага, сэрээ бусад хоолны хэрэгслийг мэдэрч таних, ялган нэрлэх;
 - Устай савны бариул, цоргыг тэмтэрч мэдэрч, барьж, зөөж аяганд савнаас усыг аюулгүйгээр хийж сурах;
 - Уух, идэх хэмжээгээ тохируулан аягалах;
 - Амны алчуурыг зөв хэрэглэх;
 - Бусдын туслалцаагүйгээр хүссэн зүйлээ ширээн дээрээс авч идэх;
 - Хооллосон ширээгээ цэвэрлэх, аяга, тавгаа угаах;
 - Аяга тавгаа байх газарт нь хийх;
 - Хоолны ширээ дээрх хоол, эд зүйлийн байрлалыг мэдэх “цагийн тооны байрлалын арга”-ыг хэрэглэх;
 - Олон нийтийн газар зөв хооллох;
 - Хоолны хэрэгсэл, хоолыг бусдын туслалцаагүйгээр авч идэх, хэрэглэх, буцаан тавих;
 - Хоолны ширээнд зөв сууж, зөв зохистой үг хэллэг хэрэглэх;
 - Шаардлагатай тохиолдолд бусдаас дэмжлэг авах;
 - Хоолны амтны талаар сэтгэгдлээ илэрхийлэх;
 - Бусдаас дэмжлэг хүсэх, зэрэг хооллож эхлэх.
- *Бие даан хувцаслаж сурах:*
 - Хувцас байгаа байрлалд очиж чаддаг болох;
 - Өмсөх хувцсаа таних, хувцасныхаа бүрэн бүтэн байдлыг шалгах;
 - Хувцаснуудыг материал, хэлбэрээр нь ямар хувцас болох, ямар нөхцөлд өмсдөг эсэхийг ялган таних, нэрлэх;
 - Өрөөний аль ч хэсгээс өрөөн доторх хувцасны шүүгээ, өлгүүрийн байрлалыг олох;
 - Хувцасны шүүгээний тавиур, өлгүүр, шургуулгын байрлалыг мэддэг болох;
 - Шүүгээн дотроос өөрийн өмсөх гэж буй хувцсыг материал, зориулалтаар нь ялган олох;
 - Гутлын тавиурын байрлал болон тавиур дээрх гутлыг олох;
 - Гутлаа зориулалтаар нь ялган таних, зөв өмсөж, тайлах, байранд нь буцаан тавих;
 - Гутлаа бүрэн үдсэний дараа явах;
 - Гутал арчлах хэрэгслээ ялган таних, зөв хэрэглэх;
 - Хувцас угаах өрөө, өрөөн доторх угаалтуур, угаалгын түмпэн, угаалгын нунтгийн байрлалыг олж сурах;
 - Угаах хувцсаа ялган тавих, угаасан хувцсаа эмхэлж цэгцлэх;
 - Хувцсаа гараар болон угаалгын машинаар угаах;
 - Гэрийн болон гадуур өмсөх хувцсаа ялган таних;
 - Хувцаслах, хувцсаа угаахдаа багш, гэр бүлийнхэнтэйгээ харилцан ярилцах, тэдний дэмжлэгийг авах.
 - *Хувийн ариун цэврийг сахих:*
 - Гар нүүр, шүдээ угаахад хэрэглэх зүйл, тэдгээрийн байршлыг мэдэх;
 - Хувийн ариун цэврийн хэрэгслээ зүйлийг тогтсон газарт байрлуулж, хадгалах;
 - Оо, сойз, алчуур болон ариун цэврийн бусад хэрэгслээ ялган таних;
 - Ус, тосгуурыг зөв хэрэглэн гар, нүүр, шүдээ зөв угаах;
 - Гар нүүр, шүдээ угаах хугацаа болон дараалал, хэрхэн угаах аргыг мэдэх;
 - Гараа болон шүдээ угаахдаа шаардлагатай тохиолдолд бусдаас хэрхэн тусламж хүсэх;
 - Ариун цэврийн хэрэглээ хэрэглэж дуусаад тогтсон байршилд тавих.
 - *Гэрийн нөхцөлд усанд орж чаддаг болох:*
 - Гэртээ байдаг шүршүүрт болон ванны байршлыг мэдэх, бусдын тусламжгүйгээр олох;

- Усанд ороход хэрэглэгдэх зүйл, тэдгээрийн зориулалт, байршлыг тогтоон, саадгүйгээр олж хэрэглэн усанд орох;
 - Биеэ дарааллын дагуу угаах, арчих, өөрийн хувийн эд зүйл, ариун цэврийн хэрэгслийг зөв хэрэглэн, байранд нь буцаан тавих;
 - Усанд орохдоо бусдаас тусламж хүсэх;
 - Ямар зүйлс хэрэглэх, ямар үед нь хэнээс тусламж хүсэж болох, хэрэгцээтэй зүйлээ гэрийнхэндээ хэлж тусламж авах.
- *Гэрийн нөхцөлд үсээ угааж, хатааж, самнаж сурах:*
 - Гэрийн нөхцөлд үсээ угаах орчин, хэрэглэгдэх зүйлийг таньж олох;
 - Ус угаах хэрэгслийг байршлаас нь олж хэрэглэх, буцаан тавих, хадгалалтын талаар мэдэх;
 - Саван, шампунь, ангижруулагчийг ялган таних, хэрэглэх;
 - Саван шампунь ашиглан үсээ зөв угааж хатааж, самнах;
 - Үсээ хэзээ угаах, үс угаахад юу хэрэглэх, өөрөө бие даан үсээ угаахад ямар нэгэн саад бэрхшээл тулгарахад бусдаас тусламж хүсэх;
 - Тусламж авах талаар бусадтайгаа санаа бодлоо хуваалцах.
- *Гал тогооны хэрэгсэлтэй танилцах:*
 - Гал тогооны хэрэгслүүдийн байршлыг олох /аяга, таваг, хувин савны тавиур гэх мэт/;
 - Халбага, аяга, таваг, хоолны сав суулгыг ялган таних, нэрлэх, зориулалтыг мэдэх;
 - Хутга, хайч зэрэг ир, ирмэг, үзүүртэй хэрэгслийг зөв барих, аюулгүй хэрэглэх;
 - Хэрэгслүүдийн ялгаатай болон төсөөтэй байдал, зориулалтын талаар ярилцах; эдгээрийг хэрэглэх талаар бусдаас дэмжлэг хүсэх;
 - Бусдын тусламжтай болон бие даан хэрэглэх.
- *Хүнсний бүтээгдэхүүнтэй танилцах:*
 - Хүнсний бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хаана, ямар саванд хадгалдаг болохыг мэдэх, хайж олох;
 - Хүнсний бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс жимсгэнэ хэрэглэхийн ач холбогдлыг мэдэх;
 - Гурил, будаа, гоймон, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг гэх мэт бүтээгдэхүүнийг таних, ялгах;
 - Хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг мэдэх, нэрлэж сурах, мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар ялгах;
 - Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний талаар багш болон гэр бүлийнхэнтэй ярилцаж, санал бодлоо хуваалцах;
 - Бүтээгдэхүүнийг эрж олох, байрлалыг олохгүй тохиолдолд бусдаас дэмжлэг хүсэх;
 - Ногоо арилгах, гурил зуурах гэх мэт энгийн үйлдлийг бусдын тусламжтай болон бие даан хийх.
- *Ор, дэрний хэрэгслийг зөв хэрэглэн өөртөө үйлчилж сурах:*
 - Орны байршлыг мэдэрч, гэр, өрөөний аль ч орчноос олж очих;
 - Орны дээд доод хэсэг, ор, дэрний хэрэгслийг мэдэх, нэрлэх;
 - Орны дэвсгэр, хөнжлийн даавуу, хөнжил, гудас, дэр, бүтээлгийн гадна тал, дотор тал, дээд, доод хэсгийг ялган таних;
 - Орны хэрэгслийг мэдэрч зөв хэрэглэх;
 - Унтах ороо цэгцтэй засах;
 - Унтсан ороо эмх цэгцтэй хураах, орыг эмх цэгцтэй байлгах;
 - Ор засах, хураахдаа бусдын дэмжлэгийг авах.
- *Тасалгааны цэцэг, ургамал арчлах:*

- Тасалгааны цэцэг, ургамлыг ихэвчлэн хаана байрлуулдаг болохыг мэдэх, байрлалыг тогтоох;
 - Тасалгааны цэцэг, ургамлын ач холбогдлыг мэдэх;
 - Зарим ялгааг мэдэрч болон үнэрээр ялган таних;
 - Цэцэг, ургамлыг цонх, тавиар дээр зөв байрлуулах;
 - Цэцэг, ургамлыг хугацаанд нь услах, арчлах;
 - Цэцэг, ургамлын нэрийг тогтоох;
 - Цэцэг, ургамлын үнэр, хэмжээ, цэцэг, навчны хэлбэр болон ач холбогдлын талаар ярилцах, тайлбарлах;
 - Тасалгааны цэцэг, ургамлыг хэрхэн арчлах талаар бусдад тайлбарлах, мэдрэмжээ илэрхийлэх.
- *Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг ашиглаж сурах:*
 - Гэрийн орчинд өдөр тутам хэрэглэдэг цахилгаан хэрэгслийн нэрийг мэдэх;
 - Гэр ахуйн цахилгаан хэрэгслүүдийн хэлбэр, хэмжээгээр нь ялган таних;
 - Гэр ахуйн цахилгаан хэрэгслийг хэрэглэхэд бэлтгэх, хэрэглэсний дараа аюулгүй болгох;
 - Шаардлагатай тохиолдолд цахилгаан хэрэгслийг ажиллуулах талаар бусдын дэмжлэг авах;
 - Өдөр тутам ашиглагддаг гэр ахуйн цахилгаан хэрэгслүүд гэрийн болон өрөөний аль хэсэгт байрладаг, хаана байдгийг мэдэх;
 - Цахилгаан хэрэгслийн зориулалтыг мэдэх;
 - Цахилгаан хэрэгслийг бусдын тусламжтай болон, бие даан аюулгүй ашиглах;
 - Цахилгааны залгуур /разетка, вилк/-ны зориулалтыг мэдэх;
 - Хананд байрлуулсан болон зөөврийн залгуурын байрлалыг тогтоох, бие даан олох;
 - Цахилгаан хэрэгслийг хамгийн тохиромжтой байрлалд залгаж ашиглах;
 - Цахилгааны залгуурыг тохирох залгуурт залгах, тухайн хэрэгслийг зааврын дагуу ашиглах, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллуулах;
 - Ахуйн цахилгаан хэрэгслийг ялган таних, тус бүрийн зориулалтыг мэдэх;
 - Цахилгаан хэрэгсэл тус бүрийн ажиллах зааврын дагуу ажиллуулах;
 - Цахилгаан хэрэгслийг хэрхэн ажиллуулах талаар багшийн болон бусад хүмүүсийн зааварчлааг сонсох ойлгох, санал бодлоо хуваалцах;
 - Аюулгүй ажиллагааны дүрмийн талаар ярилцах.
 - *Сургуулийн орчинд биеэ авч явах дүрмийг мөрдөх:*
 - Сургуулийн орчин, өдөр тутмын үйл ажиллагаатай танилцах;
 - Сургуулийн доторх болон гаднах орчны зориулалтыг танин мэдэх;
 - Хичээл ба хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед ямар дүрэм журам баримталдаг талаар мэдэх;
 - Сургуулийн доторх, гаднах орчинд байдаг эд зүйлс, шат, түшүүр, тавилга, нийтийн эзэмшлийн таньж мэдэх;
 - Сургуулийн дотор, гадна байдаг эд зүйлсээр баримжаалан явах;
 - Сургуулийн дотоод дүрмийг мөрдөн багш, бусад ажилтнууд, үе тэнгийнхэнтэйгээ зөв харилцах;
 - Шаардлагатай тохиолдолд бусдаас дэмжлэг хүсэх, чаддаг зүйлээрээ бусдад туслах;
 - Эелдэг харилцаатай байж биеэ зөв авч явах.
 - *Анги дотор аюулгүй байдлаа ханган биеэ авч явах:*
 - Ангийн хаалга, анги доторх тавилга, эд зүйлийн байрлал, хоорондын зайг баримжаалах;
 - Анги дотор бусдын дэмжлэгтэй буюу бие даан явах;

- Анги танхим дахь самбар, цонх, хаалга, өөрийн болон бусдын ширээ, сандал бусад эд зүйлсийн байршлыг тогтоох, тэдгээрийг нэрлэх, зориулалтыг мэдэх, хэрэглэх;
 - Ангид байгаа тавилга хэрэгсэл бусад эд зүйлсийг нэрлэж, ялган таньж мэдэх, зориулалтаар нь хэрэглэх;
 - Анги дотор явах болон ангид байгаа эд зүйлсийг хэрэглэх талаар бусдадаа тайлбарлах;
 - Шаардлагатай нөхцөлд багшаас болон ангийн бусад хүүхдээс тусламж хүсэх, бусдад туслах.
- *Сургуулийн коридор болон шатаар өгсөж, уруудаж явах:*
 - Сургуулийн хонгил /коридор/, түүнд байрлах эд зүйл, цонхны байршил, ангиудын байрлал, шатны байрлалыг мэдрэмжээ ашиглан мэдэх;
 - Хаалга хаашаа онгойдог, шатны бариул хаана байгаа эсэхийг мэдэж, очих газраа саадыг тойрон, аюулгүй байдлаа ханган зорчих;
 - Ангийн хаалга, хаалганы бариул, шатны бариул, шатны эргэлт, коридорт байрлах эд зүйл, онцлог тэмдэг тэмдэглэгээг ялган таних;
 - Эд зүйл, тэмдэг тэмдэглэгээг баримжаалан явах;
 - Сургуулийн хонгилоор явах болон шатаар өгсөж уруудахдаа бусадтай мөргөлдөхгүйн тулд хэрхэн биеэ авч явах;
 - Шаардлагатай тохиолдолд бусдаас тусламж хүсэх, бусдад туслах.
- *Сургуулийн өрөө тасалгааны байрлалыг мэдэж, үйлчлүүлэх:*
 - Цайны газар, эмчийн өрөө, биеийн тамирын заал, номын сангийн зориулалт, хаана байдгийг мэдэх;
 - Өрөө, тасалгаа тус бүрд хэн ажилладгийг мэдэх, ажилтанд хүсэлтээ илэрхийлж үйлчлүүлэх;
 - Өрөө тасалгаанд ямар тавилга хэрэгсэл байдгийг мэдэх, зориулалтын дагуу ашиглах;
 - Цайны газар, биеийн тамирын заал, номын сан зэрэгт очих замыг тогтоох, бусдын дэмжлэгтэй буюу бие даан очих;
 - Өрөө тасалгаанд байрлах үндсэн эд зүйлс, тавилга хэрэгсэл болон таних тэмдэг тэмдэглэгээг ялган таньж, нэрлэх, хэрэглэх;
 - Цайны газар, эмчийн өрөө, номын сан зэргээс үйлчилгээ авахын тулд холбогдох хүмүүстэй харилцах, өөрийн хүсэлт хэрэгцээгээ илэрхийлэх.
- *Ариун цэврийн өрөөг ашиглах:*
 - Ариун цэврийн өрөөг хэрхэн олж очих, хаалга, түгжээ, суултуур, угаалтуур, гар хатаагч зэрэг нь хаана байгааг мэдэх;
 - Ариун цэврийн өрөөний хаалганы түгжээ хэрхэн түгжигдэж онгойдог, жорлонгийн суултуурын таг, суултуурын ус татах товчлуур, шингэн саван, гар ариутгагч, гар хатаагч зэргийг ялган таних, хэрэглэх;
 - Ариун цэврийн өрөөнд өөрийн аюулгүй байдлыг хангахын тулд хэн нэгэн байгаа эсэхийг асуух, шаардлагатай тохиолдолд хэнд хандах, хэрхэн тусламж хүсэх, бусдад туслах.
- *Мөнгөн тэмдэгтийг ялгаж, хэрэглэх, дэлгүүрээс худалдан авалт хийх:*
 - Мөнгийг хаана хадгалах, гэр болон сургуулийн орчмын дэлгүүрийн байрлалыг мэдэх;
 - Мөнгөн тэмдэгтийг ялгаж сурах, хэрэглэх, дэлгүүрийн ажилтан, худалдагчийн тусалцаатайгаар худалдан авалт хийх;
 - Дэлгүүрийн ажилтан, худалдагчийн тусалцаа авах, ээлж дараалал хүлээж сурах.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт:

“Ахуйн баримжаа” сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулах ажлыг төлөвлөхдөө харааны бэрхшээлтэй хүүхдийн үлдэгдэл хараа, хүртэх, сонсох, амтлах, үнэрлэх мэдрэхүйг ашиглан ахуйн баримжааны чадвар, дадал хэвшилд сургахад чиглэгдэнэ.

Сургалтын жишиг хөтөлбөрийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, “Дэмжлэгийн баг”-ийн гишүүд (цэцэрлэг, сургуулийн удирдлага, сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтан, анги удирдсан болон тэгш хамруулах боловсролын багш, дотуур байрны багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид) хүүхдийн өдөр тутмын амьдралд нэн шаардлагатай ахуйн баримжааны чадваруудыг бий болгох, хөгжүүлэх, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх нэмэлт ганцаарчилсан сургалт шаардлагатай хүүхдийн суралцах цагийн ачааллыг тооцож төлөвлөнө.

“Ахуйн баримжаа” сургалт нь тухайн хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сургалтын цагийн хуваарьт тусгагдана. Хүүхдийн харааны түвшин, хэрэгцээнээс хамааруулан сургалтын жишиг хөтөлбөрийн агуулгаас сонгон ганцаарчилсан (БСШУС-ын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан) сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

Ганцаарчилсан сургалтыг эцэг эх, асран хамгаалагч, багш нар хамтран хүүхдийн бие даасан оролцоог хангаж зохион байгуулна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн “Дэмжлэгийн баг”-ийн гишүүд, багш нар хүүхэд хөгжлийн танхимд хичээлийн бус цагаар харааны бэрхшээлтэй хүүхдэд ахуйн баримжааны ганцаарчилсан сургалтаар дэмжлэг үзүүлж ажиллаж болно.

Жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй:

Сургалтын жишиг хөтөлбөрийг тэгш хамруулан сургах оролцоонд суурилсан хүүхэд төвтэй, идэвхтэй сургалтын арга зүйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Арга зүй нь хүүхдийн харааны чадвар алдалтыг харгалзан, суралцахуйн ялгаатай байдлыг судалж, хэрэгцээ, чадварт суурилан танин мэдэхүйн болон өөртөө үйлчлэх чадварыг дэмжихэд чиглэнэ.

Хичээлийн үеийн сахилга бат, дэг журмыг мөрдөж хэрэгжүүлэхэд бусад хүүхдийн адил шаардлагыг биелүүлнэ.

Сургалтын хэрэглэгдэхүүн, орчин:

Сургалтын орчин гэдэгт танхимын болон танхимаас гадуурх байгаль, нийгэм, соёлын орчныг ойлгоно

Сургалтын хэрэглэгдэхүүнийг хоолны хэрэгсэл, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, тасалгааны цэцэг, сургалтын макет загвар, мультимедиа зэрэг хэрэглэгдэхүүн, эд юмсыг ашиглан өнгөний ялгарал сайтай, тэмтэрч мэдрэх боломжтойгоор бэлтгэнэ.

Орон нутаг, сургуулийн нөөц боломжийг харгалзан сургалтад аюулгүй, хямд, ашиглахад хялбар, олдоц сайтай гарын доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж болно.

Үнэлгээ

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүүхдийг оношлох болон явцын үнэлгээгээр үнэлнэ.

Оношлох үнэлгээ нь харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, хөгжлийн түвшнийг тодорхойлох, хүүхдийн хэрэгцээ, бодит чадвар, хөгжих, сурах онцлогийг тусгасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, багшийн арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Явцын үнэлгээ нь хүүхдийн сургалтын үйл ажиллагааны оролцоо, өөртөө үйлчлэх чадвар, тэмтрэх мэдрэхүйн хөгжил, баримжаалах чадварт гарч буй ахиц өөрчлөлтийг үнэлж, цаашид суралцах зорилтыг тодорхойлох, багш тухайн хүүхэдтэй ажиллах арга зүйд зохицуулалт хийх, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээллээ хангахад шаардагдах мэдээлэл цуглуулахад чиглэнэ.

Явцын үнэлгээг дараах загварын дагуу хүүхдэд эзэмшүүлэхээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусгасан шалгуур тус бүрийг эзэмшсэн байдлыг 5 түвшнээр үнэлнэ.

Энэхүү үнэлгээ болон “Ахуйн баримжаа” сургалтын жишиг хөтөлбөрт үндэслэн дараагийн шатны ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний агуулгыг сонгон төлөвлөж хэрэгжүүлнэ.

Шалгуур	Чадвар					Гүйцэтгэлийн хувь	Дүгнэлт, тайлбар
	Аяга, таваг, данх зэрэг савтай цай, хоолны температурыг мэдрэх, халуун хоол, цайг асгахаас болгоомжлох	Ширээнд суух, устай аягыг хайж олох, аягатай шингэнийг зөв барьж уух;	Аяга, тавагтай хоолыг мэдэрч, халбага, сэрээг зөв хэрэглэх	Хоол идэхдээ ширээ, аяга, халбаганыхаа зайг тохируулах	Хоолны ширээ, сандал, гал тогооны хэрэгслийг мэдэрч, ялган таних		
Огт чаддаггүй-1							
Бага зэрэг чаддаг-2							
Дундаж түвшинд чаддаг-3							
Чаддаг-4							
Маш сайн чаддаг-5							

Үнэлгээг багш өөрөө хийхийн зэрэгцээ Дэмжлэгийн баг, сургуулийн удирдлага, орон нутгийн боловсролын газар үнэлж болох бөгөөд багшийн ажлын үнэлгээнд харгалзаж болно.

-----000-----



ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ОРОН ЗАЙ, ХӨДӨЛГӨӨНИЙ ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

Үндэслэл, хэрэгцээ:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд түүний дотор харааны бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах, сурч, хөгжих үйл ажиллагааг дэмжих ганцаарчилсан сургалт, дэмжлэг, заах арга зүйн тохируулга, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Харааны бэрхшээлтэй хүүхдэд хязгаарлагдмал жижиг орон зайд баримжаалах, биетийн болон орон зайн төсөөлөлтэй болох замаар чөлөөт орон зайд баримжаалж сурах, очих газраа баримжаалах, дохио зангааг ойлгох, бусдын тусламжтайгаар хамтран орон зайгаа баримжаалах, цагаан таяг болон бусад нэмэлт техник хэрэгслийг ашиглаж орон зай, хөдөлгөөний чиг баримжаагаа тодорхойлох, бие даан явах ойлголт, мэдлэг, чадвар эзэмшүүлэх нь тэдний суралцах, нийгэмших нэн чухал хэрэгцээ юм.

Энэхүү хэрэгцээг хангах зорилгоор харааны бэрхшээлтэй хүүхдэд “Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа” хичээлийг ганцаарчилсан сургалтаар зохион байгуулдаг бөгөөд сургалтын хөтөлбөрийг өнөөг хүртэл хичээл заадаг багш боловсруулан хэрэгжүүлж ирсэн байна.

Иймд “Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа” хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулан батлах нь харааны бэрхшээлтэй хүүхдэд орон зай, хөдөлгөөний баримжаа олгох сургалтыг багш системтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг болох юм.

Сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулахад баримталсан зарчим:

- Хүүхдийн эрт үеийн хөгжлийн үнэлгээ, онцлог хэрэгцээ, чадварт суурилсан байх
- Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, ялгаварлан гадуурхалтгүй, тэгш, хүртээмжтэй байх;
- Хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн агуулгыг уян хатан сонгох боломжтой байх;
- Багш хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөх, зохион байгуулах, ахиц өөрчлөлтийг үнэлэх боломжтой байх.

Хөтөлбөрийн зорилго:

“Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа” сургалтын жишиг хөтөлбөрийн зорилго нь харааны бэрхшээлтэй хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, танил биш орон зайд баримжаалах, дасан зохицох, нийгмийн амьдралын орчинд аюулгүй, эсэн мэнд явах ойлголт, арга барил, ур чадвар эзэмшүүлэх, нийгэмшлийн чадварын алдагдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн амьдралд бие даан оролцоход бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн агуулга:

- *Хадгалагдан үлдсэн мэдрэхүйг хөгжүүлэх, ашиглах*

Гар, хурууны мэдрэхүйг хөгжүүлэх:

- Гар хурууны тэмтрэх мэдрэхүйг ашиглан биетийг олох, нэрлэх, ашиглах;
- Биетийг ширхгээр нь ялгах, биетийг хэмжээгээр ялгаж олох;
- Ахуйн эд зүйлс болон хичээлийн хэрэгслийг гадаргуугийн шинж (арзгар, үслэг даавуу, гялгар, хатуу, зөөлөн эд зүйл гэх мэт)-ээр нь ялган таних;
- Биет, юмсыг жингээр нь (хүнд, хөнгөн) ялгах;

- Гурвалжин, дөрвөлжин, дугуй, олон өнцөгт дүрсийг хэлбэр хэмжээгээр нь ялгах, ижил дүрсийг тэмтэрч олох;
- Хатуу картон цаасаар хийж, хэдэн хэсэгт хуваасан дүрс, зургийг эвлүүлэх;
- эд зүйлсийг эд материал (модон, төмөр, хуванцар, цаасан)-аар нь таних ангилах;
- Будаа, гурилыг мэдэрч таних, талх, гурилан бүтээгдэхүүнийг ялган таних;
- Эд зүйлсийн халуун, хүйтнийг мэдрэх.

Хөлийн мэдрэхүйг хөгжүүлэх:

- Хөлийн улны мэдрэхүйгээр биетийн гадаргуугийн хэлбэрийг таних, нэрлэх, ашиглах;
- Мод, цаас, төмөр гэх мэт зүйлсийг хөлийн улаар мэдрэх, гол шинжийг нь таних (мод хатуу, цохиход чанга дуугүй, төмөр хатуу, энгийн нөхцөлд хүйтэн, хурдан халдаг, цохиход чанга дуу гардаг, цаас-зөөлөн шажигнаж дуугардаг гэх мэт);
- анги танхим болон байр, гэрийн шалны гадаргууг мэдрэх /плита, мод, паркетан шал гэх мэт/;
- Төрөл бүрийн гадаргуутай замыг мэдрэх (элсэн зам, асфальтан зам, модон зам, өвстэй, цастай халтиргаатай зам, давсан зам, брайл замыг мэдрэх).

Сонсох мэдрэхүйг хөгжүүлэх:

- Ертөнцийн дуу авиа, чимээгээр юмс, үзэгдэл, амьд ба амьгүй биеийг таних, нэрлэх, ашиглах;
- байгалийн дуу авиаг сонсох, ялгах /салхи шуурга, бороо, тэнгэр дуугарах гэх мэт/;
- хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтыг ялган сонсох (хөгжмийн дуугаралттай тоглоомууд болон бөмбөр, бүрээ, ёочин, гитар, шанз, гитар, гэх мэт), хонхны дууг мэдрэх;
- мод, төмөр, шил, цаас, хуванцар, гэх мэт зүйлсийн чимээг ялган сонсох;
- таван хошуу мал, төл мөл, нохой, тахиа, муур, шувуу гэх мэт амьтдын дуу авиаг сонсох, ямар амьтны дуу болохыг таньж нэрлэх, дуурайн дуугарах;
- олон дуу авиа дундаас нохойн хуцах, адуу янцгаах, муур мяулах гэх мэт ялган сонсох, ямар амьтны дуу сонсогдож байгааг хэлэх;
- ангийн багш, туслах багш, жижүүр, тогооч, эмч гэх мэт сургуульдаа ажилладаг багш болон бусад мэргэжлийн хүмүүсийн дуу хоолойг ялган таних;
- ангийн найз нөхдийнхөө дуу хоолойг бусад хүүхдүүдийн ярианаас ялган таних;
- ойролцоо дуудлагатай авиаг ялган сонсох, даган дуурайж хэлэх ("с-ш"авиаг ялган сонсох, "л".... авиа үгийн эхэнд орсон үгийг ялган хэлэх, "р"авиа үгийн дунд орсон үгийг даган хэлэх гэх мэт);
- аман тайлбар сонсож орон зайн баримжааг таамаглах (хүний хэлсэн орон зайн байрлалыг үзүүлэх даалгаврыг гүйцэтгэх);
- багшийн болон бусдын зааврыг сонсож, зааврын дагуу юмсын байрлалыг үгээр хэлж баруун талд, зүүн талд, дээр, доор гэх мэт байрлуулах.

Үнэрлэх мэдрэхүйг хөгжүүлэх:

- Биетийн үнэрээр орон зайд баримжаалах, ашиглах;
- Хүнсний бүтээгдэхүүнийг үнэр, амтаар нь ялгах, идэж болох болохгүй зүйлийг мэдэх, (гашилсан сүү, удсан махыг ялгах, цавуу, үнэртэй усыг ялган таних, кофе, сүү, давс, элсэн чихрийг үнэрээр нь ялгах);
- Халуун усны өрөө, гал зуухны өрөө, эмнэлэг, ногооны дэлгүүр гэх мэт орчныг үнэрээр нь ялгах, тухайн орон зайд баримжаалан явах.

• Хязгаарлагдмал, жижиг орон зайд баримжаалах чадварыг хөгжүүлэх

Гэр, сургуулийн орчинд баримжаалах:

- Гэр орон, байшин, анги, танхим, сургуулийн орчинд зүг чиг, байршил, орон зайг илэрхийлсэн үг хэллэг (баруун, зүүн, дээр, доор, өмнө, хойно, хооронд, цаана, наана, дараа, эргэн тойрон, арай дээр, арай доор, зэрэгцээ гэх мэт)-ийг зөв ойлгож, хэрэглэх;
- хоёр ба гурван хэмжээст орон зайн чиглэл (зүүнээс баруун тийш, баруунаас зүүн тийш, дээрээс доош, доороос дээш, ташуу зэрэг), түүнийг заасан үг хэллэгийг зөв ойлгох, хэрэглэх;
- Гэр орон, байшин, анги, танхим, сургуулийн орчны орон зайн талаарх зөв төсөөлөлтэй

- болох;
- ангийн эд зүйлийн болон хүрээлэн байгаа орчны эд зүйлийн орон зайн байрлалыг хооронд нь ялгах;
- гэр, орон сууц, унтлагын өрөө, хоолны өрөө, анги, эмчийн өрөө гэх мэт хязгаарлагдмал орон зайд байгаа тавилга, аяга таваг, хувцас гэх мэт биет, эд юмсыг сонсоод түүний загвар, гадаргуугийн дүрслэлтэй уялдуулан төсөөлөх, ойлгох, эдгээрийг баримжаалан бие даан явах;
- Сургуулийн орчинд байгаа мод бут, зүлэг, тоглоомын талбай, зам, барилга байгууламжийн орон зайн байршлыг зөв төсөөлөн тэдгээрийг баримжаалан бие даан аюулгүй явах.

Гадаад орчинд баримжаалах:

- Хот, тосгон, сум зэрэг амьдарч буй орчин дахь барилга байгууламж, гудамж, явган хүний зам, зам хөндлөн гарах гарц, зорчих хэсэг, газар доорх нүхэн гарцын талаар бусдын тайлбарыг сонсож төсөөлөх, бусдын дэмжлэгтэйгээр болон бие даан явах;
 - Орон сууцны барилга, ТҮЦ, дэлгүүр, нийтийн тээвэр (троллейбус, автобус, микроавтобус, такси, автомашин гэх мэт)-ийн тухай төсөөлөлтэй болох, бусдын дэмжлэгтэй болон бие даан үйлчлүүлэх;
 - Амьдарч буй орчиндоо аюулгүй явж сурах, соёл, ахуй, засаг захиргааны байгууллагуудын байршлын талаар төсөөлөлтэй болох, бусдын дэмжлэгтэй болон бие дан үйлчлүүлэх.
- **Хязгаарлагдмал болон чөлөөт орон зайд баримжаалан хөдөлгөөнөө зохицуулах чадварыг хөгжүүлэх**

Танил, хязгаарлагдмал орон зайд баримжаалах:

- Анги болон дотуур байр, сургууль, гэр орон гэх мэт танил, хязгаарлагдмал орон зайд өөрийн байрлалыг тодорхойлох (ангийн хаалганы дэргэд, цонхны хажууд, дотуур байрны үүдэнд гэх мэт);
- алхах, явах үедээ биеийн байрлалаа зөв авч явах, байж болох саадаас сэргийлж бие даан явах;
- өөрийн байрлалтай харьцуулан биет, юмсын байрлалыг тогтоох, тайлбарлах;
- гэрийн болон ангийн эд хогшил хаана байгааг өөрийн байрлалтай харьцуулан хэлэх, түүнд хүрэх, эмх цэгцтэй байрлуулах;
- биеийн тамирын заал, эмчийн өрөө хаана байдгийг баримжаалах, төсөөллөө тайлбарлах, эдгээр өрөө тасалгаанд бие даан очих;
- биеийн эд эрхтний байрлалыг заах, эд юмсын байрлалыг тайлбарлан эхлэх, бусдын зааврын дагуу эд юмсыг байрлуулах;
- Зааврын дагуу юмсыг байрлуулах /том гурвалжны баруун талд дугуй дүрсийг, дугуй дүрсийн зүүн талд хамгийн жижиг гурвалжин байрлуулах гэх мэт/;
- Баримжаалах цэгтэй харьцуулан эд юмсын байршлыг зүг чиг заасан үгээр илэрхийлэн тайлбарлах (ширээний дэргэд, ширээнээс хол, ширээн доогуур, ширээний цаана гэх мэт);
- Танил хязгаарлагдмал орон зайд өөрийн мэдрэмжид тулгуурлан явах чиглэлийн "зураг-зам" зарчмаар баримжаалах, сургууль, сургуулийн гаднах орчин, гудамж зам, талбайд бие даан, чөлөөтэй баримжаалж явах.

Чөлөөт орон зайд баримжаалах:

- Явах замын орон зайг баримжаалах анхны төсөөлөлтэй болох, явах чиглэлийн орон зайн дүрслэлийг тодорхойлох, явах чиглэлийн зураглалыг бүхэлд нь гаргах;
- явах чиглэлдээ бие даан чөлөөтэй баримжаалан явах, өөрийн амьдардаг орчны талаар «явах зам судалгаа» явуулах, бүдүүвч зураглал гаргах;
- гол ба туслах гудамжийг ялгах, гудамжны замын гадаргууг судлах, гудамжинд юу юу байрладаг, ямар онцлогтой болохыг судлах, мэдэх, замын зорчих хэсгийг хашлагатай

- үгүйг тогтоох;
 - аюулгүй зорчих замыг сонгох, замын саадыг, ногоон байгууламжийг тодорхойлох, нүхэн гарц, гүүрэн гарц, гэрлэн дохио, хот доторх өөрт чухал ач холбогдолтой нийтийн тээврийн чиглэлийг судлах;
 - тээврийн хөдөлгөөнийг өөрийн хөдөлгөөнтэй холбон хянах, (автобусны зогсоолын байршил, зүй тогтлыг мэдэх, явах замд тохиолдох аюултай газруудыг тодорхойлох;
 - замд таарах ухсан нүх, цоорхой, нарийн хэсгүүд, зам хөндлөн гарах хэсгийг тодорхойлох, хамгийн аюулгүй замыг сонгох, явах замаа бие даан төлөвлөх, явах;
 - хотын гол гудамж, талбайн нэр, байршлыг мэдэх, хотын түүх дурсгалт газрууд, соёл, худалдааны төвийн байршлыг брайл зураг, бичвэр, аман тайлбараар ойлгож мэдэх
 - хот дотор багш эсвэл эцэг эхийн хяналт дор аялал хийх;
 - танихгүй хүнээс тусламж хүсэх, эргэн тойрны хүмүүсээс санал болгож буй тусламжийг хүлээн авах;
 - цагаан таягийн үндсэн үүрэг, хараагүй хүнийг таягаар чиглүүлэх арга техникийг хэрэглэх, дэмжлэгийн зориулалттай туслах хэрэгсэл ашиглах, явах.
- **Очих газар, баримжаалах зүйлээ судлах үеийн биеийн байрлалыг мэдэх, дохио зангааг ойлгох, ашиглах**
 - Орон зайг судлах үеийн биеийн байрлалыг мэдэх;
 - ангийн эд хогшлыг судлах явцад биеийн байрлал, дохио зангааг зөв хэрэглэх;
 - үлдэгдэл хараа, хүрэх мэдрэхүйг ашиглах;
 - барилга байгууламжийн хана дагуу явах үед гарын хөдөлгөөнөө удирдах;
 - байгууламжийн доторх эд зүйлсийг судлах үедээ биеийн байрлалаа удирдах;
 - суух, босох, хосоороо явах, бие даан хана дагуу явах, шатаар өгсөх, уруудах үеийн биеийн байрлалыг ойлгож мэдэх;
 - уншиж бичих, хичээллэх үедээ зөв суух, шаардлагагүй илүүц хөдөлгөөнийг зогсоох.
- **Бусдын тусламжтай хамтран баримжаалах**
 - Хөтөчтэй хосоороо алхах үед хөтчийн болон өөрийн байрлалыг ойлгох, хамтран баримжаалах;
 - бусдын тусламжтай янз бүрийн орчинд баримжаалан явах, хамт яваа хүний биеийн байрлалыг ойлгож, хамтдаа алхаж сурах;
 - нарийн гудамж, гарцаар явах үед хамт яваа хүний гараас барих, дагаж явах аргад сурах, хөтчийн хэлсэн "дээшээ, доошоо шат, замын хашлага, баруун талд нүх байна гэх мэт" үгэн зааварчилгааг гүйцэтгэх;
 - зам хөндлөн гарахдаа дуут гэрлэн дохиог сонсож, ойлгох, зөв хэрэглэх ("Ногоон гэрэл аслаа.", "Гарц зөвшөөрөгдсөн байна, явцгаая", "Анхаар", "Дараагийн дохиог хүлээгээрэй" дохиогоор зам хөндлөн гарч сурах);
 - бусдаас тусламж хүсэх, үйл ажиллагаанд хамтран оролцох баримжаалан явах;
 - бусдаас тусламж хүсэх, үйл ажиллагаанд хамтран оролцох сэтгэл зүйн бэлтгэлтэй болох, тусламж хүсэх хүнээ зөв сонгох, тусламж хүсэх чадвартай болох;
 - бусадтай харилцах харилцааны соёлд сурах, хичээл дээрээ "туслагч"-тай ажиллах,
 - согтуу болон өөрт нь гэм хор учруулж болзошгүй хүнийг үг, үйлдэл, харилцааны байдлаар нь таньж өөрийгөө хамгаалах;
 - хэн нэгэн "зогс, машин!", "анхаар, нүх!", "зүүн тийш!", "баруун тийш!" гэх мэт заавар өгвөл зогсож зөв шийдвэр гаргах.
- **Цагаан таяг болон орон зайн баримжаа олгох бусад техник хэрэгслийг ашиглаж сурах**
 - Орон зайн чиг баримжаа олгоход цагаан таягийн үүрэг, таягийн төрлийг мэдэх, таягийг өөртөө тохируулан сонгох;
 - Цагаан таягийг таягаа зөв атгах, барих, хэрэглэх;

- Цагаан таяг ашиглан явах “диагоналийн арга” эзэмшин хавтгай шалтай танил орон зайд явах, цагаан таягийг баруун, зүүн гараараа ашиглах, таяг хөлд ойртох эсвэл саадтай тулгарвал хөдөлгөөнөө зогсоох;
- Цагаан таягтай явах “байнгын холбоо барих арга” хэрэглэх;
- Цагаан таягийн тусламжтайгаар явах зам дахь гадаргуугийн өөрчлөлт, шалны түвшний өөрчлөлт, саад бэрхшээлийг илрүүлэх;
- Цагаан таягтай явах үеийн биеийн байрлал, таяг барих арга техникийн зааварчилгааг ойлгох, хэрэгжүүлэх;
- Цагаан таягтай явах үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг ойлгох, мөрдөх;
- замаар явахдаа эд зүйлсийг цагаан таягаараа мэдэрч таних, таамаглах, таамаглалаа батлах;
- цагаан таяг ашиглан гэр доторх янз бүрийн гадаргуу (паркет, плита, хивс, хулдаас) болон гаднах замыг (асфальт, шороо, өвс, шороо чулуу) таних;
- цагаан таягийн тусламжтайгаар хөл доорх гадаргуугийн түвшний өөрчлөлт, хана, гишгүүр, хөлийн доорх зүйл гэх мэт саадыг мэдрэх;
- саад бэрхшээлийг мэдэрч хариу үйлдэл үзүүлэх, замын хашлага, гишгүүрт тээглэх, унахаас сэргийлэх, бусдын тусламжгүй зорчих;
- цагаан таягийг хэрэглэх үед сэтгэл зүйн өөдрөг мэдрэмжтэй, өөртөө итгэлтэй явах.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт

Сургалтын жишиг хөтөлбөрийг хүүхдийн харааны бодит чадвар, сурах арга барил, танин мэдэхүйн болон хөдөлгөөн, орон зайд баримжаалах чадварын ялгаатай байдлыг харгалзан ганцаарчилсан сургалтаар хэрэгжүүлнэ.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, “Дэмжлэгийн баг”-ийн гишүүд (цэцэрлэг, сургуулийн удирдлага, сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтан, анги удирдсан болон тэгш хамруулах боловсролын багш, дотуур байрны багш, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчид) орон зай, хөдөлгөөний чиг баримжааны төсөөлөл, ойлголтын түвшин, онцлог хэрэгцээнд тохируулан агуулгыг сонгож, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (БСШУС-ын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан) боловсруулна. Хүүхдийн харааны түвшин, хэрэгцээнээс хамаарч сургалтын жишиг хөтөлбөрийн агуулгыг ямар хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа сургалт нь тухайн хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг сургалтын цагийн хуваарьт тусгана.

Сургалтыг тухайн хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн харааны чадварын түвшнийг (харааны бүрэн алдагдалтай эсвэл сул хараатай) харгалзан туслалцаа, зөвлөгөө өгч ажиллана.

Танхимын бус сургалтаар экскурс аялал, туршилт ажиглалт, кинотеатр, музей, түүхийн дурсгалт газар, үйлчилгээний газарт орон зай, хөдөлгөөний чиг баримжааны сургалтыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхэд анхаарна.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Сургалтын жишиг хөтөлбөрийг тэгш хамруулан сургах оролцоонд суурилсан хүүхэд төвтэй, идэвхтэй сургалтын арга зүйгээр хэрэгжүүлнэ.

Сургалтыг хүүхдийн харааны чадвар алдалтыг харгалзан, суралцахуйн ялгаатай байдлыг судалж, тэдний хэрэгцээ, чадварт суурилан танин мэдэхүйн болон амьдрах ухаан, орон зай хөдөлгөөн, нийгэмшлийн чадварыг дэмжих үйлд тулгуурлан ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулахын зэрэгцээ хамтран суралцах, харилцах, бусадтай харилцах, мэдээлэл солилцох, бусдаас тусламж хүсэх зэрэг чадвар эзэмшихэд чиглэсэн үйлийн орчин бүрдүүлэхэд анхаарна.

“Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа” сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд харааны бэрхшээлтэй хүүхдэд бичвэр материалыг брайлаар орчуулж өгөх, том үсгээр хэвлэсэн материал, шинэ мэдээлэл, агуулгыг заахдаа харилцан ярилцах, бичсэн заавар,

зурагт тайлбарыг уншиж өгөх, тайлбарлах, бодит амьдралын жишээгээр тайлбарлаж хийсвэрлэх сэтгэхүйг хөгжүүлэх, бодит загвар, эд юмс, хэрэглэгдэхүүнийг ашиглан гар, хөлөөр тэмтрэн мэдрүүлэх зэргээр хүрэлцэхүйн мэдрэмжийг үйлийг тасралтгүй хөгжүүлнэ.

Шинэ мэдлэг, мэдээллийг олж авах, ойлгох, ахуй амьдралд хэрэглэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт байдлаар дахин давтан ганцаарчилсан байдлаар тайлбарлах, асуулт асуух, хариулт өгөх, хүүхдийн бие даасан оролцоог дэмжих, бие даасан байдлыг хүндэтгэх, сургалтын цагийг уян хатан төлөвлөх нь өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхийг анхаарч хүрэлцэхүйн мэдрэмжийг ашиглан тэмтрэх болон сонсголын заах аргазүйг хослуулан сургалтыг зохион байгуулна.

Хичээлийн үеийн сахилга бат, дэг журмыг мөрдөж хэрэгжүүлэхэд бусад хүүхдийн адил шаардлагыг биелүүлнэ.

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Сургалтын орчин гэдэгт танхимын болон танхимаас гадуурх орон зай, хөдөлгөөнөө зохицуулах зам талбай, байгаль, нийгэм, соёлын орчныг ойлгоно.

Анги, танхимд хүүхдийн сонирхол хэрэгцээнд нийцсэн, орон зайг баримжаалах, тухайн орчинд хөдөлгөөнөө зохицуулж сурах боломжит орчин бүрдүүлж, тухайн орчинд бие даан явж сурах, танил бус орчинд орон зай, хөдөлгөөн зохицуулж сурах, хөгжих боломжтой, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан орчин бүрдүүлсэн байхад анхаарна.

Хүүхдэд цэцэрлэг, сургуулийн орчныг танилцуулах, дасгах, анги танхим, шат, коридор зэрэгт байгаа явахад хөлд саад болох зүйлсийг арилгах, шатны ирмэг, гишгүүрийг тод өнгийн тууз, будгаар тодруулах, гар, хөлийг гэмтээж болзошгүй үзүүр, ирмэгтэй зүйлс байгаа эсэхийг нягтлах, арилгах, зөөлөвчтэй болгох, ариун цэврийн өрөөний хаалгыг авч хөшигтэй болгох буюу нээх, хаахад хялбар болгох зэргээр тэдэнд ээлтэй орчин бүрдүүлнэ.

Хувцасны шүүгээ, тавиурын хаалгыг хаах, хүүхдийн суудлыг багш, самбарт ойр байхаар хуваарилах, ангийн гэрэлтүүлгийг зохистой байлгах, хүүхэд хөлийн улаар шалан дээр бүтэн гишгэсэн байх суудлыг тохируулна.

Брайл бичгийн машин эсвэл гар аргаар брайлаар бичих төхөөрөмж, брайл номыг байршуулах тохиромжтой, зай талбай гаргах, харааны түвшнээс хамааруулан том үсгээр хэвлэсэн, бичсэн материал бэлтгэх, томруулдаг шил, аудио хуурцагт хичээлийн материалыг суулгах, дэлгэц уншигч (яриа хөрвүүлэгч), дуу хоолой танигч, скайнер буюу дүрс буулгагч, брайл принтер зэргээр суралцах үйлийг дэмжинэ.

Орон нутаг, сургуулийн нөөц боломжийг харгалзан сургалтад аюулгүй, хямд, ашиглахад хялбар, олдоц сайтай гарын доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж болно.

Үнэлгээ

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүүхдийг оношлох болон явцын үнэлгээгээр үнэлнэ.

Оношлох үнэлгээ нь харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, хөгжлийн түвшнийг тодорхойлох, хүүхдийн хэрэгцээ, бодит чадвар, хөгжих, сурах онцлогийг тусгасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, багшийн арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Явцын үнэлгээ нь хүүхдийн сургалтын үйл ажиллагааны оролцоо, орон зай, хөдөлгөөний баримжаанд гарч буй ахиц өөрчлөлтийг үнэлж, цаашид суралцах зорилтыг тодорхойлох, багш тухайн хүүхэдтэй ажиллах арга зүйд зохицуулалт хийх, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээллээ хангахад шаардагдах мэдээлэл цуглуулахад чиглэнэ.

Явцын үнэлгээг дараах загварын дагуу хүүхдэд эзэмшүүлэхээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусгасан шалгуур тус бүрийг эзэмшсэн байдлыг 5 түвшнээр үнэлнэ.

Энэхүү үнэлгээ болон "Орон зай, хөдөлгөөний чиг баримжаа" сургалтын жишиг хөтөлбөрт үндэслэн дараагийн шатны ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний агуулгыг сонгон төлөвлөж хэрэгжүүлнэ.

Шалгуур	Чадвар					Гүйцэтгэлийн хувь	Дүгнэлт, тайлбар
	Гарын хурууны тэмтрэх мэдрэхүйг ашиглан биетийг ширхгээр нь ялгах	Гарын хурууны тэмтрэх мэдрэхүйг ашиглан биетийг жингээр ялгах	Биетийн үнэрээр орон зайд баримжаалж явах	Өөрийн амьдардаг орчны талаар «явах зам судалгаа» хийж сурах	Цагаан таагийг хэрэглэх үедээ аюулгүй ажллагааны дүрмийг мөрдөх		
Огт чаддаггүй-1							
Бага зэрэг чаддаг-2							
Дундаж түвшинд чаддаг-3							
Чаддаг-4							
Маш сайн чаддаг-5							

Үнэлгээг багш өөрөө хийхийн зэрэгцээ Дэмжлэгийн баг, сургуулийн удирдлага, орон нутгийн боловсролын газар үнэлж болох бөгөөд багшийн ажлын үнэлгээнд харгалзаж болно.

-----000-----